

чиглэлээр орон нутаг болон бусад тѳрийн, тѳрийн бус байгууллагатай албан ёсны хамтын ажиллагааны гэрээ байгуулж 47 байгууллагатай хамтран ажиллаж байна.

Тѳѳнчлэн хорих байгууллагын нийгмийн ажил нь ялтанд хѳдѳлмѳрийн дадлага, мэргэжил олгох замаар нийгмийн харилцаанд бие даан оролцох чадвартай иргэн болгон тѳлѳвшѳлѳх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг ѳйлдэх явдлыг бууруулахад чиглэгдэн ажиллаж байна.

Ялтныг хѳдѳлмѳрлѳлѳн, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нѳхн тѳлѳлѳх чиглэлээр 2013 оны эцсийн байдлаар тѳлбѳртѳй нийт 2834 ялтан 91.237.922.2 тѳгрѳгний тѳлбѳр тѳлѳхѳс 490 ялтан 4.425.166.8 тѳгрѳгийн тѳлбѳр тѳлѳн, 2344 ялтны 86.812.755.4 тѳгрѳгний тѳлбѳр тѳлѳгдѳтѳй байна¹.

Иймээс ялтныг ажлын байраар хангах асуудлыг тодорхой ѳе шаттайгаар хэрэгжѳлѳх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нѳхн тѳлѳлѳх ажлыг эрчимжѳлѳх, хорих байгууллагын дотоодын ѳйлдвэрлэлийн ѳйл ажиллагааг ѳргѳжѳлѳх асуудал чухлаар тавигдаж байна. Хорих байгууллагад явуулж буй нийгмийн чухал асуудлын нэг нь суллагдах ялтныг ажлын байраар хангах бѳгѳд суллагдахаас 6 сарын ѳмнѳ судалгаанд авч, чѳлѳт нийгэмд гарахад бэлтгэх тѳлѳвлѳгѳ гарган мэргэжлийн болон бусад сургалтанд хамруулж, суллагдаад бие даан амьдрах чадвар эзэмшѳлѳх, хууль сахин биелѳлѳгч, зѳв хандлагатай иргэн болгон тѳлѳвшѳлѳх ажлыг эрчимжѳлѳх, сургалт, нѳлѳллийн ажлыг орон нутаг дахь засаг захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах шаардлагатай.

Дѳгнѳлт

Хорих байгууллагын нийгэм, сэтгэл зѳйн мэргэжлийн ѳйлчилгээг тогтмолжуулах зорилгоор:

- ШШГТ хуульд нийгмийн ажлын холбогдох бѳлѳг, заалт оруулах.
- нийгмийн ажилтныг мэргэшѳлѳх бодлого боловсруулж, нийгмийн ажлын ѳр нѳлѳг дѳэшлѳлѳх, ѳѳрѳг хариуцлагыг бий болгох.
- хоригдогсдыг нийгэмшѳлѳх, сэтгэл зѳйн ѳйлчилгээ ѳзѳлѳх ѳйл ажиллагааньталаар бусад орны туршлагыг судлах, нѳвтрѳлѳх.
- хорих анги, шийдвэр гѳйцэтгэх албаны нийгмийн ажилтан, сэтгэл зѳийчйг мэргэшсэн боловсон хѳчнээр бѳрдѳлѳх, шаардлагатай нэгжид орон тоог бий болгох.
- хорих байгууллага дахь нийгэмшѳлѳх ѳйл ажиллагааны ажилд тѳрийн болон тѳрийн бус, олон нийтийн байгууллагыг татан оролцуулах механизм бий болгох, энэ чиглэлээр эрх зѳйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай юм.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
811 дѳгээр дамжааны сонсогч,
ахмад Г.Энхболд*

ШШГБ-ЫН АЛБАН ХААГЧДЫН АЮУЛГѳЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

2012 оны УИХ-ын сонгуулийн ѳр дѳнд бий болсон “Шинэчлэлийн засгийн газар”-ын хэрэгжѳлѳж буй ѳйл ажиллагааны нэг гол хэсэг нь хууль зѳйн салбарт

¹ ШШГЕГ-ын нэгдсэн тоо бѳртгэл, судалгаа, шинжилгээний тасгийн 2013 оны тайлан.

явуулж буй шинэчлэл, реформ юм. Энэхүү шинэчлэл эхэлснээс хойш яригдаж байгаа нэг чухал сэдэв бол **аюулгүй байдлыг хангах** ойлголт билээ.

ШШГБ-ын аюулгүй байдлыг хангах гэдэг нь тухайн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулах гадаад, дотоод таатай орчин бүрдсэн байхын зэрэгцээ учирч болох аюул заналыг урьдчилан харах, аюулыг давах чадамжтай байхыг хэлнэ гэж ойлгож болно. Үүнийг дотор нь:

Байгууллагын аюулгүй байдал /объект, байгууламжийн, нууцлалын, мэдээллийн, техник, тоног төхөөрөмжийн гэх зэрэг асуудлууд яригдана.

Хүний буюу харилцаанд оролцогч субъектын аюулгүй байдал:

Албан хаагчийн аюулгүй байдал

Сэжигтэн, яллагдагч /хоригдогч/, ялтны аюулгүй байдал яригдана.

Үүнээс албан хаагчийн аюулгүй байдлыг хангах ажиллагаан, тулгамдаж буй асуудлуудын талаар дор яригдана.

Манай байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, эрх зүйн актууд нь 1931 оноос /Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хууль/ эхлэх ба 2002 оны ШШГТХ хуртэл 10 хууль батлагдан гарсан байдаг.

Эдгээр хуулиудад албан хаагчийн АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ гэсэн үг үүсгэлдэр дурьдагдаагүй боловч албан хаагч нь үүрийнх болон бусдын амь биеийг хамгаалахын тулд галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэж болох тухай л бусад хуулиудад тусгаж үгсн байна.

Албан хаагчдын аюулгүй байдлыг хангагдах гэдэг нь тухайн албан хаагч хуульд заасан эрх зүргээ хэрэгжүүлсэний төлөө гадаад, дотоод орчноос аюул занал учрахгүй байх, хэрэв аюул занал учирвал үүнийг давах чадамжтай байхыг хэлнэ. Үүр хэлбэл дотоодоос буюу хоригдогч, ялтан, бусад албан хаагчдын зүгээс /дээд тушаалын албан тушаалтан нь ямар нэгэн байдлаар хууль бус үйл ажиллагаа явуулахыг шаардах, хууль бус үйл ажиллагааг нуун дарагдуулахыг оролдох, эмэгтэй албан хаагчдад ажлын байран дахь бэлгийн дарамт учруулах гэх мэтээр эрхшээлдээ оруулах/ төнд нөлөөлөх, амь бие, эрүүл мэндэд нь халдах явдлаас найдвартай хамгаалагдсан байх ёстой.

Гадаад орчны нөлөөлөл гэдэгт хоригдогч, ялтны хань хамсаатнууд нь ямар нэгэн байдлаар нөлөөллийг оролдохыг /гэр бүлд нь заналхийлэх, эд хөрөнгөд нь хохирол учруулах, мөнгө санхүүгийн байдлаар эрхшээлдээ оруулах эсвэл бүр хорих анги руу гаднаас халдан довтлох гэх мэт/ ойлгож болох юм.

ШШГЕГ нь 2013 оны 4 дүгээр сард бүтцийн үүрчлөлтүүр шинээр Аюулгүй байдлын хэлтэстэй /цаашид АБХ гэх/ болсон. Гэхдээ энэ хэлтсийг байгуулсан нь сайшаалтай, хэлтсийн үйл ажиллагааг үргэжлэх, бэхжүүлэх олон ажлууд хийгдэж байгаа /тусгай тасгийг нэгтгэх, шинээр нохойн албатай болох гэх мэт/ боловч шинэ тутам хэлтсийн хувьд дутуу дулимаг зүйлс олон байгааг хэлэх нь зүйтэй.

Тухайлбал АБХ болон Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс нэг дүрмээр үйл ажиллагаагаа явуулж байгаа ба төнд тухайн хоёр хэлтсийн зааг ялгааг тодорхой гаргаж үгсгүй байдаг. Иймээс АБХ нь урьдчилан сэргийлэх ажлаа эрчимжүүлэхээс илүү ХШДАХ-ийн адил үргэдл, гомдлын мөрөөр ажил явуулах, шалгалт хийх нь

төвлөх явагдаад байгаа нь тус хэлтсийн 2013 оны тайлангаас тодорхой харагдаж байна. Иймээс эрх зүйн орчноо тодорхой болгох нь нэн чухал асуудал юм.

Энэ шалтгаалж нийт албан хаагчдаас АБХ бол тэдний өөрсдийн эрх ашиг, аюулгүй байдлыг хангах газар гэхээсээ илүү өргөдөл гомдол хэлсэн авч шалгалт явуулдаг, өөрөөр хэлбэл “ШШГБ доторх цагдаа, До яамныхан” гэсэн ойлголттоо хэсэг нь дийлэнх болжээ.

Албан хаагчийн аюулгүй байдлыг дараах байдлаар ангилж, тусгайлан авч үзэж болно. Үүнд:

Хэрэгжүүлж буй чиг үүргээр нь:

- Хорих байгууллагын албан хаагчийн аюулгүй байдал
- Шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдал

Хүйсээр нь:

- Эмэгтэй албан хаагчийн аюулгүй байдал
- Эрэгтэй албан хаагчийн аюулгүй байдал

Нийгмийн асуудлаар нь:

- Албан хаагчийн гэр бүлийн аюулгүй байдал,
- Албан хаагчийн санхүүгийн аюулгүй байдал гэх мэт.
- Хорих байгууллагын албан хаагчийн аюулгүй байдал

Сүүлийн 10 жил улс орны хэмжээнд эрүүгийн нөхцөл байдал хүндэрсэн, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдэх нь ихэссэн, гэмт хэрэг нь зохион байгуулалтад орж улс төр, бизнес дамнасан гэмт бүлэглэлүүд өрсөх хандлагатай болсон энэ жилд хорих байгууллагын албан хаагчдын аюулгүй байдал эрсдэлд орох магадлал өндөр болсон.

Албан хаагчийн амь биед халдсан тохиолдол 2013 оны 4 дүгээр сараас энэ оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд 10 гаруй удаа удаа бүртгэгдсэн байдаг. Ийм тохиолдол маш ноцтой хор хохирол учруулдаг нь 1996 онд Авдарантад болсон учралаас тодорхой харагдана. Ийм жилд албан хаагч өөрийгөө хамгаалах орчин өөрийн зэвсэг, хэрэгсэл зайлшгүй шаардагдаж байгаа юм. Тухайлбал резинэн бороохойг ялтан шууд халдсан тохиолдолд хэрэглэж болох тухай зөвшөөрсөн боловч “тусгай хэрэгсэл хэрэглэх журам”-д зөвхөн дал хавсарч юм уу үзэг хонгонд нь цохиж болно гэсэн байна. Энэ нь ялтныг араас нь юм уу эсвэл халдлага нь дууссаны дараа доош нь харуулж байгаад хашраах хэлбэрээр л хэрэглэгдэхээр ойлгогдож байна. Иймэрхүү зөрчилтэй асуудлууд олон байгаа тул зайлшгүй жилд хэрэглэх цахилгаан буу гэх мэт орчин өөрийн хэрэгсэлээр хангах асуудал чухал юм.

Бас нэг анхаарал татаж асуудал нь одоо ид яригдаж байгаа цаазаар авах ялыг халах тухай асуудал юм. Одоо ерөнхийлөгчийн зөгөөс уг ялыг түтгэлзүүлээд байгаа ба ингэснээр гянданд ял эдлэж байгаа ялтны тоо бараг 100 хүрээд байна. Энэ болж гяндангийн нөхцөл байдал илт хүндэрч эхэлсэн. Хэрэв цаазаар авах ялыг бүр халсан тохиолдолд энэ тоо ихсэх ба нөхцөл байдал түдий хэмжээгээр хүндэрнэ гэсэн үг. МУ дахь эрүүгийн ялын дээд хэмжээгээр /25-30 жил/ яллуулсан хүмүүс дахин ямар ч гэмт хэрэг үйлдсэн ял нэмүүлэх асуудал яригдахгүй тул ялтнууд оргохоор аза үзээд алдах, энэ жилдээ саад болсон албан хаагчийн амь, биед халдах магадлал ихсэх дүр зураг харагдаж байна.

Энэ Үед одоогийн хууль, эрх зүйн байдал, харуул хамгаалалтын хич хэрэгсэлээр аюулгүй байдлаа хангахад маш хндрэлтэй нь ойлгомжтой учир ил сайжруулах нь чухал юм.

Шийдвэр гйцэтгэгчийн аюулгүй байдал. Энэ оны 2 сард Схбаатар аймаг дахь ШГА-ны шийдвэр гйцэтгэгч С албан Үргээ гйцэтгэж яваад тлбр тлгчид буудуулж нас барсан нь тэдний аюулгүй байдал эмзэг байгаагын хамгийн том дохио.

Гэхдээ энэ хэргээс болж ч анхаараад байгаа асуудал биш, Үнгрсн 2013 оны шийдвэр гйцэтгэгчдийн цугларалт дээр шийдвэр гйцэтгэгч нарыг хуульд заасан тусгай хэрэгсэлээр /бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч/ нэг брчлэн хангах тухай яригдаж байсан боловч тсв, санхүүгийн байдлаас болж одоо хртл хангаж амжаагүй л байна.

Шийдвэр гйцэтгэгчид нь эд хрнгр хураах гэх мэт ажиллагаа хийх Үед “Цагдаагийн байгууллагын туслалцаа авч болно” гэсэн хуулийн заалт байдаг боловч энэ нь практикт тэр бр хэрэгжихэд хндрэлтэй байдаг. Шийдвэр гйцэтгэгчдийн ажиллагаа /хнхдийн тэтгэвэр гэх мэт/ брт цагдаа дагуулж явуулах боломж ч тухайн байгууллагад байдаггүй байх.

Одоо практикт тухайн алба нь хянагч, жолооч гэх мэт албан хаагчдаа хамт явуулдаг ч тэдгээр хмсс нь шийдвэр гйцэтгэх ажиллагаанд оролцох эрх зүйн субъект биш /иргэний Үргийн хувиар л оролцож болно/ юм. Энэ мэт олон асуудлыг нэг мр тодорхой болгох шаардлагатай байгаагаас хамгийн нэгдгээрт ШГА-дуудад ШГ ажиллагааны Үед аюулгүй байдлыг хангах орон тооны албан хаагчдыг бий болгож, тэдний эрх зүйн байдлыг тодорхой зааж гх нь зйтэй.

Эмэгтэй албан хаагчийн аюулгүй байдалтнийг хангах ажиллагааг тусад нь авч Үзэх шалтгаан нь тэд бэлгийн дарамт, бэлгийн хчирхийлэлд рртх магадлалтай байгаатай холбоотой. Хорих ангийн амьдралын бсэд Үрэг гйцэтгэж байгаа эмэгтэй албан хаагчид нь бэлгийн хчирхийлэлд рртх эрсдэл ихтэй юм. Саяхан дугаар хорих ангийн сувилагч М нь амьдралын бс дэх эмнэлэгийн ррнд 1 ялтны халдлагад рртж байсан тохиолдол ч Үнийг нотлож байна.

Бид амьдралын бсэд тр хугацаагаар нэвтрээд гарах эмэгтэй албан хаагчдыг харуул хамгаалалтын эрэгтэй албан хаагчтай цуг явуулж болох ч ажлын 8 цаг, бр 24 цаг амьдралын бсэд Үрэг гйцэтгэх шаардлагатай нийгмийн ажилтан, сувилагч зэрэг албан хаагчдыг байнга эрэгтэй албан хаагчаар хянуулж байх хн хчний ч бололцоогүй байдаг.

Үнээс урьдчилан сэргийлэхийн тулд юуны Үмн амьдралын бс дэх бх объектыг камержуулж, камерын хяналтыг тасралтгүй, тогтмол байхаар зохион байгуулах, эмэгтэй албан хаагчдын албан ррнд дохиоллын систем суурилуулах /банкны системтэй адил/ шаардлага урган гарч ирж байна.

Бас нэг хндгдох ёстой асуудал нь ажлын байран дахь бэлгийн дарамт. Эмэгтэй хний бэлгийн эрх члл, халдашгүй байдалд дээд албан тушаалын хн нь Үрийн эрх мэдлийг ашиглан халдах, бусад байдлаар дарамтлах /ил цагаар ажиллуулах, ажлаар хэт шахах г.м./ зэрэг нь тний аюулгүй байдалд шууд халдаж буй асуудал юм. Нэг ялтнаас звхн “би чамд хайртай” гэсэн захиа ррний хаалгаар нь шургуулснаас болж эмэгтэй албан хаагчид сэтгэл зүйн дарамт, стресст автаж ажил Үргээ чллтэй гйцэтгэж чадахгүй байдалд хрсэн судалгаа ч байдаг.

Эрэгтэй албан хаагчийн аюулгүй байдал. Яагаад түүнийг тусгайлан авч үзэж болох вэ гэхээр тэд эмэгтэй ялтан, албан хаагчдад “бэлгийн дарамт учруулсан” гэж гүйцэтгэх явдал гарч байсантай холбоотой. /407 дугаар ангид гарсан жишээ/

Албан хаагчдын гэр бүлийн аюулгүй байдал. Бид эвхлэн ажил үргээ гүйцэтгэж байх үед албан хаагчдынхаа аюулгүй байдлыг хангах тухай ярих биш бас тэдний гэр бүлийн аюулгүй байдлыг ч тооцож байх нь зүйтэй. Учир нь ШШГБ-ын албан хаагч нь дээр бүр гэмт хэрэгтэн, тлбүр тлүгчидтэй харьцаж тэдний заналхийлэлд өртөж байдаг бөгөөд дээрх байдлаас болж сэтгэл зүйн дарамтанд орж хуулийн дагуу албан үүргээ гүйцэтгэхээсээ ч шантарч байсан /хорих 413 дугаар ангид болсон жишээ/ тохиолдлууд бий. Ялтнууд хэдий хорих ангид хоригдож байгаа ч тэдний хань, харилцаа энгийн иргэдийн дунд алхаж байгаа үед албан хаагчийн гэр бүлийн гишүүд нь дарамт болон элдэв халдлагад өртөхгүй байх ямар ч баталгаа алга. Энэ тохиолдолд тэдний гэр бүлийг хамгаалах хууль, эрх зүйн зохицуулалт одоогоор алга. Хэрэв ялтан хорих ангидаа хоригдож байгаа гэж үзэх юм бол эрх чөлөөтэй явж байгаа, тус хонзон өвлөсөн тлбүр тлүгчүүс /гэр орон, эд хөрөнгөө хураалгасан гэх мэт/ ирэх халдлага илүү аюултай, илүү бодитой харагдаж байна. /Говь-Алтай аймагт тлбүр тлүгч нь шийдвэр гүйцэтгэгч Б-г гэрт нь ирж дарамталсан асуудал 2013 онд гарч байсан/.

Өнгөрсөн онд Хорих 405 дугаар анги /гяндан/-ийн хянагч Б нь гэр бүлийн 4 гишүүний хамт гэртээ шатаж нас барсан золгүй тохиолдол гарсан. Хэдийгээр галын дүгнэлт “ойрхон асгасан үнсний цог салхинд хийссэнээс болж” гэж гарсан ч энэ асуудлыг түүний эрхэлж байсан ажил, гүйцэтгэж байсан үүрэгтэй нь холбогдуулж дүн шинжилгээ хийвэл өөр олон тохиолдолд ШШГБ-ын албан хаагч “үнсээ ойрхон асгаад, гал алдах” эрсдэл гарсан үед хамгаалагдах ямар ч аргагүй байна.

Үүнээс урьдчилан сэргийлэх бас нэг арга бол хууль зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй хорих ангиудыг нэгтгэх асуудал бөгөөд тлвүрсн том хорих ангитай болсноор түүнийг дагаж хорих байгууллагын албан хаагчдын хотхонтой /сургууль, эмнэлэг, дэлгүүр гэх мэт газрууд нь хотхон дотроо/ болох нөхцөл бүрдэнэ. Ингэвэл албан хаагчдын гэр орон нь хаана байдаг нь илүү тодорхой болно гэж муугаар бодож болох ч хэрэв харуул хамгаалалт гэх мэт зүйлсийг нь цогцоор нь шийдэж чадвал тэднийхээ гэр бүлийг хамгаалах бас нэг нөхцөл болж болно.

Албан хаагчийн санхүүгийн аюулгүй байдал. Нийт массын ихэнх буюу ялангуяа ахлагчийн бие бүрэлдхүүний хувьд цаг наргүй, нөргөх хөнд хөчир түүрийн албыг хашиж байгаа үндсэн шалтгаан бол шууд хэлэхэд цалин хөлс авч, гэр бүлээ тэжээх явдал гэж хэлэхэд нэг их буруудахгүй байх.

Эх оронч үзэл, түүрийн албаны нэр хүндийг үндэрт өргөх хөсөл, цэргийн цол, хангамж эдлэх гээд олон олон шалтгаан байж болох ч хамгийн чухал нь тогтмол орлоготой байж, түүгээрээ гэр бүлээ тогтвортой авч явах /элдэв зээл, хөнгөлөлтөд хамрагдах гэх мэт/, нийгмийн баталгаагаа хангах явдал юм.

Гэтэл манай түүр түүрийн буюу түүрийнхэн тлүү зүтгэж буй /сүүлийн үед нийтийн алба гэх/ албан хаагчдын нийтлэг бэрхшээл болох эдийн засаг, нийгмийн баталгаа хангалтгүй буюу цалин хөлс нь ажилчдынхаа хэрэгцээг хангаж чадахгүй байгаагаас албан хаагчид маань сэжигтэн, ялтан, тлбүр тлүгч гэх мэт

субъектүүдтэйгээ хувийн харьцаанд орж, мөнгө болон бусад эд зүйлс хувьдаа авах асуудал буурахгүй байгаагаар тодорхойлогдож байна.

Нэгэнт санхүүгийн байдлаар тухайн субъектээсээ хараат байдалд орсон албан хаагчид бэх хэлбэрээр аюулгүй байдал нь алдагдах нөхцөл бүрдэж байгаа юм. Дээрх асуудлыг гагцхүү “цалин хөлс бага, амьдралд хөрдөггүй” гэх шалтагаар хаацайлаад нөхрөх нь зохистой, үүнд “албан хаагчдын боловсрол, мэдлэг дутуу, төрийн албан хаагч гэсэн нэр төрөө ухамсарладаггүй, болхи мунхаг байдал, ял шийтгүүлсэн хэмээс болон тэдний ар гэрийнхний явуулж буй байнгын өдөөн хатгалга, мөн удирдлагын буруу арга барил, дутуу дулимаг ажиллагаа” гээд олон шалтаг, шалтгааныг дурьдаж болох боловч хамгийн гол нь ар гэрийн амьдрал тааруу, цалин хөлс нь хаанаа ч хөрдөггүй байдал гэдэгтээ хэн ч маргахгүй байх.

Ялангуяа сүүлийн үед “цагаан захтан”-уудын гэх хэргүүд ихсэж, улс, иргэдээс хэдэн арван тэрбум төгрөг залилсан, шамшигдуулсан гэх хэмээс олноороо хорнгдож байна. Манай улсын төр 500 сая, 5 тэрбум, бүр 15 тэрбум төгрөгийн “хэргээр” хоригдож байгаа хүнийг сардаа 500.000 хүрэхтэй гүйтэй төгрөгийн цалинтай хүнээр мануулчихаад, “тэдний нөхцөлд бөөг авт” гэж үүрэгдэн суух нь эмгэнэлтэй ч, инээдтэй ч гэмээр асуудал биш гэж үү?

"Манайх дан бүрээстэй гэрт өвлөжсүж байгаа. Гэрт төлөх нөхрөс байхгүй. Ээлжнээс буугаад гэртээ харихаасаа сэтгэл өвддөг. Эхнэр маань нөхд нь бөлтэлзсэн хоёр хүндээ тэврээд "хоолны юм олж ирээ болов уу" гээд чичрэн суугаа гэж бодохоор хэцүү байдаг. Тэгээд би "100.000 төгрөг үгье. Ямар ч хамаагүй нэг гар утас оруулаад үгчих" гэсэн саналаас нь татгалзаж чадаагүй юм. Одоо ингээд бүр ажилгүй боллоо доо" гэсэн тайлбар тавиад үйлж байгаа хүнтэй би нэг бус удаа таарч байсан ба ийм хүнтэй шударга ёс, төрийн албан хаагчийн ёс зүй ярихаасаа илүү сайн хүнрэг, сайхан хүнхэн, хурдан моринд хэдэн арав, хэдэн зуун сая төгрөг "цацдаг" боловч "төрийнхүү" албан хаагчдийг ийм байдалд хүргэж байгаа төр засгийн удирдлагатай шударга ёс, ёс зүй яримаар санагдсаныг нуугаад юун.

Эцэст нь дээрх асуудлуудыг эрдэмтэн, судлаач та бөхөн цаашид лавшруулан судлаад, шийдвэрлэх арга замыг тодорхойлно гэдэгт итгэж байна.